

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 дугаар сарын 13

Дугаар 81

Улаанбаатар хот

Төрийн дээд шагналд  
уламжлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван тавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, эрүүл мэнд, хууль эрх зүй, соёл урлаг, боловсрол, тээвэр, худалдаа үйлчилгээ, аж үйлдвэр, барилгын салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг төрийн цол хүртээх, одон медалиар шагнуулахаар тодорхойлж Нийслэлийн Засаг даргад уламжилсугай.

2.Төрийн цол хүртээх, одон медалиар шагнуулахаар тодорхойлж буй иргэдийн материалыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлэх, тогтоолын хэрэгжилтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга (Н.Баярмөнх)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР